



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

додс оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/205

Улаанбаатар хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хүчингүй болгож, газар эзэмших эрхийг
дуусгавар болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.4, 35 дугаар зүйлийн 35.3.1, 39 дүгээр зүйлийн 39.1.4, 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/451 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа ноцтой зөрчсөн, төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй 1 (нэг) иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээ нь хүчингүй болсон тухай зохих журмын дагуу мэдэгдэж, газар эзэмшүүлэх гэрээг цуцлан, газрын кадастрын мэдээллийн сангийн бүртгэлд өөрчлөлт оруулах, хяналт тавьж ажиллахыг Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайханд)-нд даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2012 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/78 дугаар захирамжийн Ж.Жавхланбаярт хамаарах заалтыг тус өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД